



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 603

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалт, газар эзэмшил, ашиглалт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 53.9 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяад дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1 Урсгал төсөв, давсан орлогоос бэлтгэх хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хуулиар тогтоосон журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан авч, зөрчлийг таслан зогсоох;

2.2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эзэмшлийн, Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороонд байрлах, 977 м2 газрыг чөлөөлүүлэх асуудлыг хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-д нийцүүлэн байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журмыг батлан, мөрдөж ажиллах;

2.4. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2 автомашины гараашны барилгын доорх газрыг гэрчилгээжүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, холбогдох арга хэмжээ авах;

2.5. Мэргэжлийн хяналтын байгууллагаас тогтоосон акт, хөрөнгийн эрүүл ахуй, аюулгүй байдал алдагдсан бодит нөхцөл зэргийг харгалзан хоёрдугаар байрны ашиглалтыг сайжруулах зардлын асуудлыг Эрүүл мэндийн яаманд хүсэлт гарган шийдвэрлүүлэх, төсөв батлагдсан тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хөрөнгийг актлах, шинээр барих зөвшөөрөл авах;

2.6. Төв болон дотуур байранд байрлан үйл ажиллагаа явуулж буй төслийн нэгжүүдтэй Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх тухай 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолын дагуу төрийн өмчийн байр талбайг ашиглуулах гэрээ байгуулах.

2.7. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн  
603 дугаар тогтоолын хавсралт



Эрүүл мэндийн хөгжлийн төвд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн  
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

| Д/д      | Зөрчил, дутагдлын<br>утга                                                                                                  | Хариуцах<br>нэгж                                   | Мөнгөн<br>дүн<br>/сая<br>төгрөг/ | Зөрчигдсөн эрх<br>зүйн акт                                                                                                                                                                                                  | Зөрчил,<br>дутагдлыг<br>арилгах талаар<br>авч хэрэгжүүлэх<br>арга хэмжээ                                                                                                                                                                                        |
|----------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1        | Эрх бүхий<br>байгууллагын<br>зөвшөөрөлгүйгээр<br>хөрөнгө худалдан<br>авсан                                                 | Захиргаа,<br>санхүү,<br>дотоод<br>хяналтын<br>алба | 53.9                             | Төрийн болон орон<br>нутгийн өмчийн<br>тухай хуулийн 24<br>дүгээр зүйлийн 3<br>дахь хэсэг, Төрийн<br>өмчийн бодлого,<br>зохицуулалтын<br>газрын 2019 оны 271<br>дүгээр тогтоол                                              | Төрийн өмчийн<br>бодлого,<br>зохицуулалтын<br>газрын 2019 оны<br>271 дүгээр<br>тогтоолыг мөрдөж<br>ажиллах                                                                                                                                                      |
| 2        | Төрийн өмчийн<br>эзэмшил газрыг бусдад<br>гэрээ, төлбөргүйгээр<br>ашиглуулсан,<br>зөвшөөрөлгүй хувийн<br>хөрөнгө барьсан   | Захиргаа,<br>санхүү,<br>дотоод<br>хяналтын<br>алба | -                                | Засгийн газрын 2001<br>оны 134 дүгээр<br>тогтоол, Төрийн<br>өмчийн бодлого,<br>зохицуулалтын<br>газрын 2016 оны<br>102, 119 дүгээр<br>тогтоол, 2017 оны<br>53, 268 дугаар<br>тогтоол, 2018 оны<br>59, 293 дугаар<br>тогтоол | Газар<br>чөлөөлүүлэх<br>асуудлыг хууль<br>хяналтын<br>байгууллагаар<br>шийдвэрлүүлэх,<br>Засгийн газрын<br>2001 оны 134<br>дүгээр тогтоол,<br>Төрийн өмчийн<br>бодлого,<br>зохицуулалтын<br>газрын 2020 оны<br>49, 50, 51 дүгээр<br>тогтоолыг мөрдөж<br>ажиллах |
| 3        | Төв болон дотуур<br>байранд байрлаж<br>байгаа төслийн<br>нэгжүүдийг гэрээгүй,<br>үнэ төлбөргүй байр<br>талбайгаар хангасан | Захиргаа,<br>санхүү,<br>дотоод<br>хяналтын<br>алба | -                                |                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                 |
| Нийт дүн |                                                                                                                            |                                                    | 53.9                             |                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                 |